

**““ЖАВХЛАНТ ХАРАА ” ХК.” ХК-ийн ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН**

**ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ**

2015.04.06

Улаанбаатар хот

Хувьцаа эзэмшигчдийн хурал нь ““ЖАВХЛАНТ ХАРАА ” ХК-ийн Улаанбаатар хот дахь төв байранд 2015 оны 04 дүгээр сарын 06-ны өдрийн 10.00 цагт болов. Хуралд ТУЗ-ийн гишүүн Ш.Батжаргал , Мөнхбаяр , Батбаяр, Батзаяа , Цэндсүрэн нарын нийт 9 гишүүдийн 100 хувь ирэв.

Хуралд оролцогчдын 100 хувийн саналаар дараах асуудлыг хэлэлцэн шийдвэрлэхээр болов. Үүнд:

1. Компанийн 2014 оны ээлжит хувьцаа эзэмшигчдийн хурлыг зарлан хуралдуулахаар шийдвэр гаргах;
2. Компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэх асуудлын жагсаалтыг гаргах.

“ЖАВХЛАНТ ХАРАА ” Нээлтэй хувьцаат компанийн төлөөлөн удирдах зөвлөл нь Компанийн тухай хуулийн 59.4-т заасны дагуу 2015 оны 4 дүгээр сарын 28-ны дотор хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг зарлан хуралдуулах үүрэг хүлээсэн байдаг.

Манай компанийн хувьд жил бүр дээрх үүргээ биелүүлж ажилладаг бөгөөд 2014 оны үйл ажиллагааны үр дүнг хэлэлцэх ээлжит хувьцаа эзэмшигчдийг хурлыг 2015 оны 04 дугаар сарын 28-ны өдөр зохион байгуулахаар зарлах саналтай байна.

Ш.Батжаргал ХК холбогдох хууль тогтоомжоор хүлээсэн үүргийн дагуу хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг хуралдуулахаар товыг гаргаж байгааг дэмжиж байна.

**Шийдвэрлэсэн нь:**

1. “ЖАВХЛАНТ ХАРАА ” ХК-ийн ээлжит хувьцаа эзэмшигчдийн хурлыг 2015 оны 04 дугаар сарын 28-ны өдөр хуралдуулах;

2. Хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцох эрх бүхий хувьцаа эзэмшигчдийг бүртгэх өдрийг 2015 оны 04дугаар сарын 21-ны өдрөөр, хувьцаа эзэмшигчдийн хурлын зарыг хүргэж эхлэх өдрийг 2015 оны 04дүгээр сарын 11-ны өдрөөр тус тус тогтоож, хувьцаа эзэмшигчдийн хурлаар дараах асуудлыг хэлэлцэхээр шийдвэрлэх. Үүнд:

- Компанийн 2014 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг хэлэлцэж батлах,

- Компанийн дүрмийн шинэчилсэн найруулга батлах,
- ТУЗ-ын хараат бус болон ердийн гишүүдэд нэр дэвчигчдийг сонгох,
- Компаний үйл ажиллагааг сэргээх төсөл батлах тухай
- Компаний үнэт цаасны арилжааг сэргээх
- Компаний аудитын тайлан хэлэлцэн батлах

3.Хувьцаа эзэмшигчдийн хурлыг Компанийн тухай хууль болон Санхүүгийн зохицуулах хорооноос баталсан холбогдох журамд заасан шаардлагыг ханган хариуцан зохион байгуулахыг Мөнхбаяр -д даалгахаар тус тус шийдвэрлэв.

Хурлын шийдвэрийг 100 хувиар батлав. Хурал 12:30 цагт өндөрлөв.



Тэмдэглэл хөтөлсөн: *Д. Сайнзаяа* ..... Д. Сайнзаяа

Тооллогын комисс: ..... Б.Батбаяр  
*Э.Цэндсүрэн* ..... Э.Цэндсүрэн